



ЕРӨӨ СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020 07 29/25 № 185
танай _____-ны № _____-т

Хандивын тайлангийн дүгнэлт

Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ерөө сумын Монгол Ардын намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Ерөө сумын Монгол Ардын намын хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайд 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ерөө сумын Монгол Ардын намын хороонд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд

• 018020437

байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 дугаар тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Ерөө сумын Монгол Ардын намын хороо нь ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА